

Санваарын хүч

Арван хоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч  
Бويد К.Пакер

Санваарын хүч гэр бүлүүдэд бат бөх төлөвшихөөс нааш түүнд байх ёстой хүч нь байдаггүй, байж ч чадахгүй.

Би өрх гэрийн тэргүүн эцгүүдэд, Сүмийн бүх гэр бүлд хандан ярьж байна.

Бид олон жилийн өмнө Ерөнхийлөгч Харольд Б.Лийгийн удирдлаган дор Сүмийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах хөтөлбөрийг эхэлсэн билээ.

Тухайн үед, Ерөнхийлөгч Томас С. Монсон: “Өнөөдөр, бидний нүдний өмнө урьд хожид байгаагүй ихээр газар аван тэлсээр байгаа нүгэл хилэнцийн хүчит давалгаа түрэн, тэмцэл өрнөж байна .... Тиймээс хүмүүний бодгалийг аврах энэхүү тулааны төлөвлөгөө биднийх биш. Энэ нь Их Эзэний нөлөө болон илчлэлтээр дамжин ирсэн юм”<sup>1</sup> гэжээ.

Эдгээр жилүүдэд Сүмийн бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн юм. Сургалтын хөтөлбөрт бүрэн бүтцийн өөрчлөлт хийлээ. Байгууллага хоорондын уялдаа холбоо, зорилгыг шинээр тодорхойлов. Санваар хэмээх үг нь холбон зохицуулах мөн бүтцийн өөрчлөлт хийсэн жилүүдэд гол үг байлаа.

Ерөнхийлөгч Монсон бас Хуучин Гэрээний баатар Гидеоны тухай ярьсан юм. Гидеон мянга мянган хүчирхэг эрчүүдээс бүрдсэн Израилын армийг удирдахаар сонгогдсон байв.

Гэвч тэрээр тэдний дундаас, ердөө 300 хүнийг л сонгож авсан юм.

Гидеон шинэ цэргүүдээ маш сонирхолтой замаар сонгожээ. Голоос ус уусан хүмүүсийн ихэнх нь “өвдөг сөгдөн . . . ууж байв”<sup>2</sup>. Тэр эдгээр хүмүүсийг сонгоогүй. Хэдхэн хүн л амандаа гараараа ус утган уусан бөгөөд тэд үргэлж сонор сэрэмжтэй байлаа. Эдгээр хүмүүс сонгогдсон юм.<sup>3</sup>

Бид “олон дайн самуун, дайны цуурхлууд, мөн хаа сайгүй газар хөдлөлтүүдийн”<sup>4</sup> үед амьдарч байна. Бошиглогдсоноор: “Бүхэл дэлхий үймээн самуунд”<sup>5</sup> байна. Мөн “Сатан уг нутагт тархсан байна.”<sup>6</sup> Сатан аливаа сайн болон зөв шударга бүхнийг устгахыг эрэлхийлдэг.<sup>7</sup> Энэ нь Бурханы дэргэдээс хөөгдсөн тэр Люсифер мөн.<sup>8</sup> Энэ бүхний талаар ирээдүйд болох зүйлсийн талаар бид нааштай бодол санаатай байдаг билээ.

Цэдэгт өгүүлснээр, “Хүн бүр өөрийн байрлал дээр зогссон”<sup>9</sup> учраас Гидеоны багахан хүч амжилтанд хүрсэн билээ.

Энэхүү “цаг хугацааны бүрэн байдлын эрин үе”<sup>9</sup> нь, Эцэг, Хүү хоёр эгэл хөвгүүн болох Иосеф Смит дээр хүрч ирснээр нээгдсэн юм.<sup>10</sup> Дараа нь, Мормоны Номыг агуулсан ялтсууд хаана хадгалагдсаныг тэнгэр элч Моронай Иосефт үзүүлэв.<sup>11</sup> Ялтсуудыг орчуулах хүч Иосефт өгөгдсөн билээ.<sup>12</sup>

Иосеф, Оливер Каудери хоёр орчуулах үедээ, баптисмын тухай уншжээ. Юу хийх ёстойг мэдэхээр тэд залбирсан юм.<sup>14</sup> Тэнгэр элч Иохан Баптист тэдэн дээр ирж, “Тэнгэр элчүүдийн тохинууллын хийгээд наманчлалын сайн мэдээний, мөн нүглүүдийн ангижралын тулд усанд умбуулалтаар хийх баптисмын түлхүүрүүдийг атгагч”<sup>14</sup> Аароны санваарыг тэдэнд хүртээсэн билээ.

Дараа нь, Их Эзэний үйлчлэлийн үед Түүнтэй хамгийн ойр дотно байсан Петр, Иаков, Иохан нар Иосеф, Оливер хоёр дээр хүрч ирэн дээд санваар<sup>15</sup> буюу “Бурханы Хүүгийн жаягийн дагуух Ариун санваар[ыг]”<sup>16</sup> хүртээв. Судруудад тайлбарласнаар, Абрахам аравны нэгийг түүнд төлдөг асан тэрхүү агуу дээд санваартан Мелкизедекийн нэрээр энэхүү санваар нэрлэгдсэн юм.<sup>17</sup>

Тэгээд энэ санваар тэдний эрх мэдэл нь болсон юм. Санваарын түлхүүрүүдээр дамжуулан, тэд тэнгэрийн бүхий л хүчийг хэрэглэх боломжтой болжээ. Тэд сайн мэдээг бүх үндэстнүүдэд хүргэхээр зарлиг болгогдсон байлаа.<sup>18</sup>

Есүс Христийн сайн мэдээгээр амьдрах нь хэзээ ч амархан байгаагүй. Түүнийг энэ дэлхийд амьдардаг байхад мөн Сүмийн эхэн үед ч адил энэ нь амар хялбар байсангүй. Сүмийн анхдагчууд үгээр дүрслэхийн аргагүй зовлон зүдгүүр, эсэргүүцэлтэй тулгарч байлаа.

Санваар сэргээгдсэнээс хойш зуун наяд жил болж байна. Бид одоо ойролцоогоор арван дөрвөн сая гишүүнтэй байна. Тийм хэдий ч дэлхий дээрх хэдэн тэрбум хүмүүстэй харьцуулахад бид өчүүхэн хэсэг нь юм. Гэвч бид өөрсдийгөө хэн гэдгийг мэддэг мөн бидэнд мэдлэг байдаг учраас бид урагш ахиж сайн мэдээг номлох ёстой.

Бид хэзээ ч тоогоороо давамгайлахгүй хэмээн Мормоны номонд тодорхой өгүүлдэг. Гэвч бидэнд санваарын хүч байгаа.<sup>19</sup>

Бошиглогч Нифай: “Мөнхүү улиран дохиох дор би Бурханы Хурганы Сүмийг болгоов, мөн энэ нь тоогоороо цөөн байв... Хэдий тийм ч, Бурханы гэгээнтнүүд байсан Хурганы Сүмийнхэн түүнчлэн бүх дэлхийн гадаргуугаар оршин байхыг би болгоов; мөн тэдний эзэмшил нь газрын гадаргуугаар бага байв”<sup>20</sup> гэж бичсэн байдаг.

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит: “Дэлхийнхтэй харьцуулах юм бол бид тоогоороо цөөхөн хэмээн хэлж болох ч бид яваандаа бүх дэлхийд нөлөөлөх Аврагчийн өгүүлсэн хөрөнгөтэй зүйрлэгдэж болно”<sup>21</sup> гэж хэлсэн юм.

Бид бүх хүн төрөлхтөнд нөлөөлж чадна. Цаг нь болоход бид ийнхүү нөлөөлж чадах нь эргэлзээгүй юм. Бид хэн гэдэг нь мөн яагаад ийм байдаг талаар мэдүүлэгдэх болно. Энэ нь бүтэшгүй зүйл мэт санагдаж болох ба тун амаргүй зүйл юм. Гэсэн хэдий ч Сатаны эсрэг тулалдаанд бид ялах нь зөвхөн боломжтой төдийгүй гарцаагүй юм.

Хэдэн жилийн өмнө би “Ахлагч бүрийн мэдэх ёстой зүйл: Санваарын удирдлагын зарчмуудын талаарх удиртгал” сэдвээр үг хэлж билээ. Хожим нь, энэ үг хэвлэгдэхэд, би нэрийг нь: “Ахлагч бүрийн мэдэх ёстой зүйл, бас эгч бүрийн ч мэдэх ёстой зүйл”<sup>22</sup> гэж өөрчилсөн юм.

Ах нараас юу шаардагддагийг хүн бүр ойлгох нь маш чухал учраас би эгч нарыг хамруулсан билээ. Өөрсдийн нөхөр, аав нар, хөвгүүд, ах нартаа нөлөөлдөг ээж нар, охид, эгч нарын анхаарал, хүч чармайлтыг таталгүйгээр хөгжин дэвжиж чадахгүй. Хэрвээ эгч нарыг үл тоомсорловол санваар агуу хүчийг алдах болно.

Санваар бол Бурханаас санваартнуудад соёрхсон дэлхий дээр Түүний нэрээр үйлдэх хүч, эрх мэдэл юм.<sup>23</sup> Санваарын эрх мэдлийг зохих ёсоор ашиглавал, санваарыг эзэмшигчид нь Бурханы энэ дэлхийд хийх байсан зүйлсийг хийдэг.

Санваарын эрх мэдэл олгох ажлыг бид муугүй хийж байна. Бид бараг газар бүр санваарын эрх мэдлийг бий болголоо. Дэлхий даяар бидэнд ахлагчдын болон дээд пристүүдийн чуулгууд байна. Гэвч санваарын *эрх мэдлийг* олгох ажил санваарын хүчийг хүртээхээс түүрүүлж байна гэж би боддог. Санваарын хүч гэр бүлүүдэд бат бөх төлөвшихөөс нааш түүнд байх ёстой хүч нь байдаггүй, байж ч чадахгүй.

Ерөнхийлөгч Харолд Б. Лий хэлсэн нь, “Тэнгэрт ийм зохион байгуулалттай болохоор бас энэ нь манай залуучуудад тусалж болох хамгийн үр өгөөжтэй арга зам болохоор бид гэр бүлүүдэд тэнгэрлэг зорилгодоо хүрэхэд туслахын тулд илүү ихийг хийх хэрэгтэй байна. Ингэснээр бид Хожмын Үеийн Гэгээнтнүүд өөрсдийн амьдралынхаа чанарыг дээшлүүлэхэд туслах болно. Үүнд туслахаас өөр ямар ч сонголт Сүмд байдаггүй мөн хэзээ ч байгаагүй гэдэг нь ойлгомжтой юм. Манай олон хөтөлбөр болон байгууллагуудын хүч чармайлт чухал боловч, эдгээр нь гэр бүлийг орлох *ёсгүй*, харин гэр бүлийг *дэмжин туслах* ёстой.”<sup>24</sup>

Ерөнхийлөгч Иосеф Ф.Смит гэр бүл дэх санваарын талаар дараах үгийг хэлжээ: “Эцэг нь өрх гэрээ тэргүүлэх байнгын эрх, үүрэгтэй бөгөөд гэр бүлийн бүхий л ажил хэрэгт түүнээс илүү эрх мэдэл эдэлдэг хүн байдаггүй. Энэ зарчмыг тайлбарлахын тулд нэгэн болсон явдлын тухай өгүүлье. Заримдаа ахлагч нар нь гэр бүлийн гишүүдэд адислал өгөхөөр

дуудагддаг. Эдгээр ахлагчдын дунд гадасны ерөнхийлөгчид, төлөөлөгчид, тэр ч бүү хэл Сүмийн тэргүүн зөвлөлийн гишүүд хүртэл байж болно. Энэ тохиолдолд ахлагч нарыг энэ чухал ёслолыг гүйцэтгэхийг хүлээгээд эцэг нь хойш суух нь зохимжтой биш юм. Энэ хэрэгт эцэг хамгийн түрүүнд оролцох ёстой. Энэ бол тэргүүлэх түүний эрх, үүрэг мөн. Хэн тос адислахыг, хэн залбирал хэлэхийг тэрээр сонгох ёстой. Сүмийн тэргүүлэх эрх мэдэлтнүүд дэргэд нь байгаа учир тэр гэр бүлдээ сайн мэдээний тэрхүү адислалыг гүйцэтгэн удирдах эрхээсээ татгалзах ёсгүй. (хэрэв эцэг нь гэртээ байхгүй толхиолдолд эх нь тэргүүлэх эрх мэдэлтэй хүнээс ёслолыг гүйцэтгэхийг хүсэх нь зүйтэй) Гэрт нь хэн байгаа нь хамаагүй, эцэг нь хоолны ширээн дээр, залбирал хийхэд тэргүүлж, гэр бүлийнхээ амьдралтай холбоотой ерөнхий удирдамжийг өгдөг билээ.”<sup>25</sup>

Вьетнамын дайны үеэр, цэргийн албанд татагдсан Сүмийн гишүүдэд зориулан бид хэд хэдэн онцгой цуглаан хийдэг байж билээ. Чикагод болсон ийм нэгэн цуглааны дараа, би Ерөнхийлөгч Харольд Б.Лийгийн хажууд зогсож байв. Тэгэхэд нэг залуу Хожмын Үеийн Гэгээнтэн, чөлөөгөөр гэртээ очихоор явж байгаа удалгүй Вьетнам уруу явах тушаалтай гэж Ерөнхийлөгч Лийд хэлэв. Ерөнхийлөгч Лийгээс адислал өгөхийг тэр залуу хүсэв.

Ерөнхийлөгч Лий “Аав чинь чамд адислал өгөх ёстой” гэж хэлэхэд би их гайхаж билээ.

Тэр залуу урам нь хугарсан байдалтай “Аав адислал яаж өгдөгийг мэдэхгүй шүү дээ” гэв.

Ерөнхийлөгч Лий, “Хүү минь чи гэртээ хариад, аавдаа дайнд явах гэж байна, тэгээд эцгийн адислалыг авмаар байна гэж хэл. Аав чинь адислал яаж өгөхийг мэдэхгүй байвал,

зүгээр л сандал дээр суугаад өг. Тэгэхэд аав чинь чиний ард зогсоод, гараа толгой дээр чинь тавина. Санаандаа орж ирсэн үгсийг хэл гэж аавдаа сануул” гэв.

Сайхь залуу цэрэг гунигтайгаар холдон явж билээ.

Хоёр жил орчмын дараа би түүнтэй дахин тааралдав. Хаана гэдгээ би санахгүй байна. Тэр надад нөгөөх явдлыг сануулаад, би хий гэснээр нь хийсэн. Би сандал дээр суугаад “Аав та миний толгой дээр гараа тавих хэрэгтэй” гэв. Бид хоёр хоёулаа санваарын хүчээр дүүрэв. Санваар байлдааны амь өрсөн аюултай саруудад надад хүч чадал, хамгаалалт болсон шүү гэж билээ.

Мөн нэг удаа би алс холын хотод байлаа. Чуулганы дараа, бид удирдагчдыг томилон, онцгойлон адисалж байв. Биднийг дуусаж байхад, гадасны ерөнхийлөгч, “Номлолд явах гэж байгаа нэг залуу эрэгтэйг бид ахлагчаар томилон адисалж болох уу?” гэж асуув.

Мэдээж, болно гэж би хариулсан.

Залуу эрэгтэй урагш гарч ирэхдээ, өөр гурван ахыг өөртэйгөө хамт гарч ирэн тойрогт зогсохыг хүсэн дохиж байгаа нь харагдав.

Би хамгийн хойд талын эгнээнд энэ хүүтэй адилхан харагдах нэг хүнийг хараад, “Тэр хүн чиний аав уу?” гэж асуув.

Залуу эрэгтэй, “Тийм ээ” гэж хариулав.

“Аав чинь чамайг томилно” гэж би түүнд хэллээ.

Тэгэхэд нөгөөх залуу, “Тэвч би өөр нэг ахаас намайг томилохыг гуйсан юм л даа” гэв.

“Залуу минь, аав чинь чамайг томилох болно, энэ өдрийн төлөө чи Их Эзэнд талархах өдөр амьдралд чинь ирэх болно,” гэж би түүнд хэлэв.

Тэгэхэд аав нь урагшаа гарч ирсэн юм.

Аз болоход тэр аав ахлагч байлаа. Тэр ахлагч байгаагүй ч удахгүй болох ёстой хүн байлаа! Зэвсэгт хүчинд, тэд үүнийг байлдааны талбар дахь томилолт хэмээн нэрлэдэг. Зарим тохиолдолд ийм зүйлс мөн Сүмд хийгддэг юм.

Аав нь хүүгээ хэрхэн томилохыг мэдэхгүй байлаа. Би гараа түүний мөрөн дээр тавиад ёслолыг гүйцэтгэх хооронд түүнд зааварчилж байв. Тэрээр ёслолыг дуусгахад хүү нь ахлагч болов. Дараа нь гайхамшигтай нэгэн зүйл тохиов. Аав хүү хоёр огт өөр хүмүүс болж тэврэлдэв. Урьд нь хэзээ ч ийм зүйл болж байгаагүй гэдэг нь тодорхой байлаа.

“Би бусад хөвгүүдээ томилоогүй шүү дээ” хэмээн тэр аав нүдэндээ нулимс цийлэгнүүлэн хэлж билээ.

Өөр хүн, тэр ч бүү хэл Төлөөлөгч ч түүнийг томиллоо гэсэн ийм сэтгэл догдлом үйл явдал болохгүй байсан байхаа.

Дэлхий даяар санваар байгаа өнөө үед бид ахлагч ,дээд прист бүрийг, санваарыг эзэмшигч бүрийг Гидеоны цөөхөн тоотой боловч хүчирхэг 300 дайчинтай адил, *байрандаа* зогсохыг



уриалан дуудаж байна. Бид одоо ахлагч, дээд прист, чуулга, бүлэг болгонд, өрхийн тэргүүн эцэг бүрд, Бүхнийг Чадагчийн санваарын хүчийг бадраах ёстой юм.

“Дэлхийн сул дорой зүйлүүд урагш гарч ирэх бөгөөд хүч чадалтнууд хийгээд хүчтэнүүдийг унагах болно”<sup>26</sup> гэж Их Эзэн хэлсэн билээ.

Бошиглогч Нифай бас, “Хурганы сүмийн гэгээнтнүүдийн дээр, мөн газрын гадаргуугаар нэг тархсан Их Эзэний гэрээ байгуулсан хүмүүс дээр буух Бурханы Хурганы хүчийг болгоов; мөн тэд ялгуулсан суунд зөв шударга байдал хийгээд Бурханы хүчээр зэвсэглэсэн байв”<sup>27</sup> гэж хэлсэн байдаг.

Бидэнд хүн болгон хэрэгтэй. Ядарсан, эцэж цуцсан эсвэл залхуу, тэр ч байтугай гэм нүгэлдээ хүлэгдсэн хүмүүс наманчлал, өршөөлөөр сэргээгдэх ёстой. Манай санваартан ах нараас олонх нь өөрсдийн боломж, Их Эзэний хүсэн хүлээдэг түвшингээс доогуур амьдарч байна.

Бид санваарын бурханлаг хүчинд итгэлтэй байж урагш давших ёстой. Бид хэн бэ, бидэнд үнэхээр юу байгаа вэ, Бүхнийг Чадагч Бурханы ажлын дагуу бид юу хийх зохистой талаар мэдэх нь урам дэм, хүч чадлын эх сурвалж болон өгөгддөг.

“Миний хэлснийг та нар хийхэд Их Эзэн бибээр үүрэг хүлээдэг. Гэвч миний хэлснийг та нар үл хийхэд та нарт амлалт байх нь үгүй”<sup>28</sup> гэж Их Эзэн хэлсэн юм.

Санваартан байхгүй өрх гэр санваартны чуулгаар хамгаалагдаж, үйлчлүүлэх ёстой. Ийм замаар, Сүм дэх ямар ч гэр бүлд адислал дутагдахгүй байх болно.

Олон жилийн өмнө, нэгэн гэр бүлийнхэн насан өндөр болсон дани эмэгтэйн орыг тойрон зогсож байлаа. Тэдний дотор дунд эргэм насны, буруу замаар орж будилж явсан хүү нь байжээ. Сүүлийн хэдэн жилийн турш тэр гэртээ ээжтэйгээ амьдарсан гэнэ.

Тэр нүдэндээ нулимс цийлэгнүүлэн, “Ээж ээ, та амьд байх хэрэгтэй. Ээж ээ, та намайг битгий орхиоч.” Тэр, “Ээж ээ, та явж болохгүй. Би таныг явуулахгүй” гэж байлаа.

Жижигхэн биетэй эмэгтэй хүү өөдөө хараад чадан ядан дани аялгуугаар, Чиний хүч хаана байна вэ? гэж асуусан гэдэг.

Паул, “Бид элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож байгаа бөгөөд Христ Есүс өөрөө булангийн Чулуу нь билээ;

“Түүний дотор бүх барилга хамтдаа нийлэн Эзэн доторх ариун сүм болохоор өсөж байна;

“Та нар ч гэсэн Сүнс дотор Бурханы орших газар болохоор Христ дотор хамтдаа байгуулагдаж байна”<sup>29</sup> гэж сургасан юм.

Их Эзэний ажил ялалтанд хүрнэ гэдэгт эргэлзэх хэрэггүй. Бид чадах бүхнээ хийж, бат нягтаар нэгдэх ёстой.

Санваарын эрх мэдэл бидэнд байна. Бид бүхнийг уялдуулан зохицуулж, зохион байгуулахын хамт, санваарын хүчийг Сүмд хэрэглэх нь эдүгээ бидний үүрэг хариуцлага мөн. Санваарын *эрх мэдэл* томилолтоор ирдэг, санваарын *хүч нь* гэрээнүүддээ хүндэтгэлтэй хандаж, итгэлтэй байж, дуулгавартай амьдарснаар ирдэг. Санваарыг зөв шударга байдлаар хэрэглэснээр хүч нь нэмэгддэг.

Аав нар аа, одоо дуудлагын чинь ариун мөн чанарыг та нарт сануулмаар байна. Гэр орноо хамгаалахад чинь Их Эзэнээс шууд ирдэг санваарын хүч та нарт байна. Хэзээ нэгэн өдөр танай гэр бүлийг дайсны хор хөнөөлөөс хамгаалах санваарын хүч чадлаас өөр бамбай байхгүй тийм цаг ирэх болно. Та нар Их Эзэнээс Ариун Сүнсний бэлгийн замаар удирдамж авах болно.

Хэдийгээр дайсан манай сүмийн цуглаануудад идэвхтэй ил тод саад тотгор учруулахгүй байгаа ч дайсан дагалдагчдынхаа хамт гэр бүлүүдийг үргэлж дайран довтолж байна.

Сүмийн бүх үйл ажиллагааны үндсэн зорилго бол эрэгтэй хүн эхнэр хүүхдүүдийнхээ хамт гэр орондоо аз жаргалтай байж, сайн мэдээний зарчмууд болон хуулиудаар хамгаалагдан, мөнхийн санваарын гэрээнүүдээр лацдан холбогдсон байх явдал мөн.

Хууль, зарчим, эрх мэдэл болгон, итгэл үнэмшил бүр, ёслол, томилолт болгон, гэрээ бүр, сүм дээр хэлсэн үг, ариун ёслол бүр, зөвлөгөө, сануулга болгон, лацдан холбогдолт, дуудлага болгон, дуудлагаас чөлөөлөх болон үйлчлэл бүр нь бүгдээрээ гэр бүл болон хувь хүнийг төгөлдөржүүлэх үндсэн зорилготой юм. Учир нь, “үхэшгүй байдал хийгээд мөнх

амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах нь миний ажил мөн миний алдар суу бөлгөө”<sup>30</sup> гэж Их Эзэн хэлсэн билээ.

Биднийг хамгаалж, удирдахын тулд Сүмд өгөгдсөн санваарын хүчийг би гэрчилж байна. Бидэнд санваар байгаа учраас бид ирээдүйд болох зүйлсээс айдаггүй. Айдас бол итгэлийн эсрэг зүйл юм. Их Эзэн биднийг, ялангуяа гэр бүлийг анхаарч халамжилдгийг мэддэг учраас бид урагш ахисаар байдаг. Түүний тухай би Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

## ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон, “Correlation Brings Blessings,” *Relief Society Magazine*, 1967 оны 4-р сар, 247.

2.

Шүүгчид 7:4-8-ыг үз.

3. Мормон 8:30, мөн Сургаал ба Гэрээ 45:26, Иосеф Смит Матай 1:23, 28-ыг үз.

4.. Сургаал ба Гэрээ 45:26, мөн Сургаал ба Гэрээ 88:91-ийг үз.

5. Сургаал ба Гэрээ 52:14.

6. Сургаал ба Гэрээ 10:22-23-ыг үз.

7. Илчлэлт 12:7-9; Сургаал ба Гэрээ 29:36-37; 76:25-26-г үз.

8. Шүүгчид 7:21.

9. Сургаал ба Гэрээ 112:30.

10. Иосеф Смит- Түүх 1:17-г үз.

11. Иосеф Смит- Түүх 1:33-34; 59-ийг үз.

12. Мормоны Номын Удиртгал; Сургаал ба Гэрээ 135:3-ыг үз.

13. Иосеф Смит- Түүх 1:68-69-ийг үз.

14. Сургаал ба Гэрээ 13:1.

15. Сургаал ба Гэрээ 27:12-23-ыг үз.

16. Сургаал ба Гэрээ 107:3.

17. Сургаал ба Гэрээ 107:2-4; мөн Еврей 7:1-4; Алма 13:15-ыг үз.

18. Сургаал ба Гэрээ 42:58-ыг үз.

19. 1Нифай 14:14-ийг үз.

20. 1Нифай 14:12.

21. Жозеф Фиелдинг Смит, in Conference Report, 1968 оны 10-р сар, 123.

22. Бойд К.Пакер, “What Every Elder Should Know-and Every Sister as Well: A Primer on Principles of Priesthood Government,”*Тамбули*, 1994 оны 11-р сар, 15-24.

23. *Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith* (1998), 141; Иосеф Смитийн

Орчуулга; Библийн хавсралт дахь Эхлэл 14:28-31-ийг үз.

24. Харольд Б.Луй, “Preparing Our Youth,” *Ensign*, 1971 оны 3-р сар, 3; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.

25. Жозеф Ф.Смит, *Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл, (1939), 287.

26. Сургаал ба Гэрээ 1:19.

27. 1Нифай 14:14.

28. Сургаал ба Гэрээ 82:10.

29. Ефес 2:20-22.

30. Моце 1:39.